



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН З А Х И Р А М Ж

2016 оны 10 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 71

Улаанбаатар
хот

Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай

1. Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийг байгуулах тухай Засгийн газар хоорондын 1949 оны хэлэлцээрийг шинэчлэх талаар оросын талтай хэлэлцээ хийх үүрэг бүхий монголын талын Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дор дурдсанаар шинэчлэн баталсугай:

- Ахлагч: -Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Б.Цогтгэрэл
- Гишүүд: -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахлах референт Н.Буяндэлгэр;
- Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын дэд захирал Д.Билэгдорж;
- Гадаад харилцааны яамны Хөрш орнуудын газрын дэд захирал Д.Хасар;
- Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Сайнзориг;
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн дарга П.Бунчинжав;
- Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга Э.Алтанзул;
- Сангийн яамны Зээл, тусламжийн бодлогын хэлтсийн дарга З.Мөнх-Оргил;
- Барилга, хот байгуулалтын яамны Хот, байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Бэлэгсайхан;
- Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Артур;


- Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Болор-Эрдэнэ;
- Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Далай ашиглалт, усан замын тээврийн хэлтсийн дарга Ж.Батболд;
- Барилга, хот байгуулалтын яамны Хот, байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн П.Энхмандах;
- Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн Д.Лхамжав;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Бодлого, төлөвлөлт, удирдлагын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баяр-Эрдэнэ;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Бодлого, төлөвлөлт, удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн В.Дарханбаатар.

Нарийн бичгийн
дарга:

-Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Б.Хулан.

2. Ажлын хэсгийн оросын талтай хэлэлцээ хийх үеэр баримтлах удирдамжийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулан хэлэлцээний явцын талаар тухай бүр Засгийн газарт мэдээлж байхыг Ажлын хэсэг (Б.Цогтгэрэл)-т үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Ерөнхий сайдын 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 203 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ